

**НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН
2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2-Р УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв сая,төгрөг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хувь
Нийслэлийн 2021-2024 оны стратегийн төлөвлөгөөний зорилго 4. Засаглалын зорилтот түвшинг бүрэн хангана.							
1	Зорилт 4.1 Төрийн байгууллагуудаас иргэн хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний зорилтот түвшинг бүрэн хангана. НХТЖҮЧ-7.3, НЗДҮАХ-6.3, НХТ- 6.1.15.						
1	Харилцаа холбоо мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглан иргэн төвтэй, ухаалаг үйлчилгээг үзүүлэх, "Цахим засаглал" төсөл хэрэгжүүлнэ. НЗДҮАХ 4.1.3.1.	13,000.0	Төслийн хэрэгжилтийн хувь	20%	70%	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад цахим шилжилт буюу төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэх, засаглалыг сайжруулах чиглэлээр төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх "Цахим Засаглал" төслийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэх төслүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж байна.	70%
2	"Цахим засаглал" төслийн хүрээнд Хэсгийн ахлагчийн систем нэвтрүүлэх	-	Нэвтрүүлсэн системийн тоо	-	1	Төрийн анхан шатны нэгж болох хороодын хэсгийн ахлагчдын үйл ажиллагааг цахимжуулах "Хэсгийн ахлагчийн систем"-ийг 2023 оны 1-р улиралд хэрэглээнд нэвтрүүлсэн. Энэхүү системээр дамжуулан хэсгийн ахлагч нар өөрийн хариуцсан хэсэгт	

					<p>амьдарч буй иргэдийн шилжилт хөдөлгөөний мэдээлэл дээр тулгуурлан судалгаа, санал асуулга авах, хууль тогтоомжийг сурталчлах, орчны зөрчил мэдээлэх, айл өрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээ мэдээллийг хүргэх зохион байгуулалтын үйл ажиллагааны ажлуудыг цахимжуулсан. Хэсгийн ахлагчийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, төлөвлөгөөг нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1488 дугаар захирамжаар батлуулсан бөгөөд төлөвлөгөөний дагуу нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газар болон хороодын 359 албан хаагч, 1535 хэсгийн ахлагч нарт систем ашиглалттай холбоотой 55 удаагийн сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Хэсгийн ахлагчийн системээр орчны 320 чиглэлээр зөрчил мэдээлэх, мэдээлэл хүргэх ажиллагааг зохион байгуулж, НҮНТ-д илгээж, харьяалагдах байгууллагуудад шилжүүлж шийдвэрлэж ажиллаж байна. 2023 оны хагас жилийн байдлаар нийт 1033 зөрчил бүртгэгдснээс шийдвэрлэсэн 972, шийдвэрлэх шатандаа явж байгаа 61 байна. Шийдвэрлэсэн 972 зөрчлөөс шийдвэрлэлтийн дундаж хугацааг</p>	100%
--	--	--	--	--	---	------

						тооцвол 8 хоног 23 цаг 49 минут байна.	
3	"Цахим засаглал" төслийн хүрээнд Digital UB гар утасны аппликейшны хөгжүүлэлт	-	Нэвтрүүлсэн аппликейшны тоо	-	1	Төр, иргэн, аж ахуй нэгж байгууллага хоорондын харилцааг шинэ түвшинд гаргах, нийслэлийн иргэд өөрт хэрэгтэй бүхий л мэдээ, мэдээллээ цаг хугацаа алдалгүй авах, санал хүсэлт, өргөдөл, гомдол гаргах, татвар, төлбөр хураамжийг төлөх, зэрэг нийслэлийн иргэдэд шаардлагатай бүхий л мэдээлэл, үйлчилгээг нэгдсэн байдлаар авах боломж бүхий "Дижитал УБ" гар утасны аппликейшныг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын "ICT Expo 2023" арга хэмжээн дээр иргэд олон нийтэд танилцуулж хэрэглээнд бүрэн нэвтрүүлэхээр ажиллаж байна.	100%
4	"Цахим засаглал" төслийн хүрээнд СӨХ конторын систем хөгжүүлэх	-	Нэвтрүүлсэн системийн тоо	-	1	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын үйл ажиллагааг цахимжуулахаар СӨХ, Конторын үйл ажиллагааг хялбаршуулж, төлбөрөө онлайнгаар төлөх, оршин суугчидтай онлайнгаар харилцах боломжийг бүрдүүлсэн системийн хэрэглэгчийн шаардлагыг тодорхойлох процессын судалгааг ОСНААУГ-тай хамтран боловсруулсан бөгөөд энэхүү системийн хөгжүүлэлтийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хариуцан хийхээр болсон.	100%

5	"Цахим засаглал" төслийн хүрээнд Өрхийн Эрүүл мэндийн систем нэвтрүүлэх	-	Нэвтрүүлсэн системийн тоо	-	1	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ачааллын цагийг тэнцвэржүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авахдаа цагийн зохион байгуулалтыг онгочтой хийх боломжтой "Ухаалаг цаг захиалгын систем", ухаалаг цаг захиалгын 140 ширхэг киоск машин болон дэлгэцийг нийслэлийн 9 дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд суурилуулахаас эхний зэлжинд СБД-ийн 16, СХД-ийн 18 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 100% суурилуулаад байна. Цаашид үлдсэн 8 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үе шаттайгаар суурилуулж байна. "Ухаалаг цаг захиалгын систем"-ийг "Дижитал УБ" гар утсны аппликэйшнтэй холбох хөгжүүлэлтийг хийж байгаа бөгөөд ингэснээр иргэн өрхийн эмнэлэгтээ үзүүлэх цагаа утсаараа авах боломжтой болох юм.	50%
6	"Цахим засаглал" төслийн хүрээнд ЕБС-ийн багш, сурагч, эцэг эхийн удирдлагын систем /40 сургууль/ нэвтрүүлэх	-	Нэвтрүүлсэн системийн тоо	-	1	Ерөнхий боловсролын сургуулийн багш болон сургуулийн олон давтамжтай гүйцэтгэдэг ажлуудыг хөнгөөчлөх, сурагч, эцэг эхэд зориулсан "eSchool сургуулийн удирдлагын цогц систем"-ийг нийслэлийн ерөнхий боловсролын төрийн өмчийн 40 сургуулийн хараглээнд бүрэн нэвтрүүлж, эдгээр сургуулиудын 101,702 сурагчдад сурагчийн үнэмлэх буюу карт олгож дээрх сургуулиудын цайны газруудад өөртөө үйлчлэх 40 киоск	80%

						төхөөрөмжүүдийг суурилуулаад байна. "eSchool сургуулийн удирдлагын цогц систем"-ийг 2023 оны сургуулийн захирал, 3901 багш, 213 ажилтан, 2668 бүлэг, 101702 сурагч бүртгэгдэн өдөр тутамдаа ашиглаж байна. Мөн сургуулийн автобусны байршлын мэдээлэл болон хүүхэд автобусандаа сууж, буусан мэдээллийг эцэг эхчүүдэд хянах боломжийг олгох зорилгоор нийслэлийн ерөнхий боловсролын төрийн өмчийн 23 сургуулийн автобусанд хяналтын камер болон карт уншигч төхөөрөмжүүдийг суурилуулж, eParent гар утасны аппликейшнийг хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.	
7	"Цахим засаглал" төслийн хүрээнд Онлайн бизнес төвийн нэмэлт хөгжүүлэлт	-	Систем хөгжүүлэлтийн н хувь	50%	70%	Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn системийн дэд систем болох "E-Business" платформд Нийслэлийн "Онлайн бизнес төв"-өөр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нийслэлийн нутгийн захиргааны 10 байгууллагын зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй 134 үйлчилгээг нэгтгэн холбож үйлчилгээний тоог нэмэгдүүлсэн бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар 453466 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 12755 хүсэлтийг ирүүлснээс 8,571 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй байгаа ба	50%

						<p>үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна.</p> <p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас бизнес эрхлэгч иргэн аж ахуйн нэгжид олгодог зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй 100 үйлчилгээг 2023 онд цахимжуулахаар техникийн даалгаврыг боловсруулсан бөгөөд хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах "Эрх шилжүүлэх" НЗД-ын захирамжийн төсөлд санал авах шатанд явж байна.</p>	
8	"Цахим засаглал" төслийн хүрээнд UB ERP системийн гар утасны аппликейшны нэмэлт хөгжүүлэлт	-	Аппликейшны хөгжүүлэлтийн хувь	70%	90%	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн UB ERP системийг нийслэлийн 1250 байгууллагын 28,400 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж албан бичгийг 100% цахимаар солилцож байна. "UB ERP" системийн гар утасны аппликейшны хөгжүүлэлтийн техникийн даалгаврыг боловсруулсан бөгөөд хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах "Эрх шилжүүлэх" НЗД-ын захирамжийн төсөлд санал авах шатанд явж байна. UB ERP систем дээр ННЗБ-уудын албан хаагчийн цаг бүртгэлийг зайнаас бүртгүүлэх мөн ННЗБ-уудын дарга нартай уулзалт хийх цаг захиалах болон албан хаагчдад өргөдөл гомдол илгээх дэд системүүдийн нэмэлт хөгжүүлэлтийг хийж байгаа бөгөөд 2023 оны 3-р улиралд</p>	70%

						хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.	
9	"Цахим засаглал" төслийн хүрээнд Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах	-	Систем хөгжүүлэлтийн хувь	-	100%	Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын "Дуудлага мэдээлэл хүлээн авах" системийн дэд модуль болох "Лавлагааны үйл ажиллагааны" системийн нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн бөгөөд цагдаагийн ерөнхий газрын серверт "Лавлагаа үйл ажиллагааг цахимжуулах" системийг байршуулж, холбогдох тохиргоонуудыг хийж систем тестлах явцад нийслэлийн прокурорын газраас нэмэлт санал тусгасан тул системд хөгжүүлэлт хийж байна. Энэхүү системээр эрүүгийн хэрэг болон зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа бүрэн цахимжина.	70%
10	"Цахим засаглал" төслийн хүрээнд Сити дашбоардын хөгжүүлэлт	-	Дашбоардын хөгжүүлэлтийн хувь	-	100%	Нийслэлийн удирдлага, хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн дэд систем болох нийслэлийн удирдлагуудыг бодитой хэмжигдэхүйц мэдээ мэдээллээр шуурхай хангах удирдлагын үйл ажиллагааг ухаалагаар удирдан зохион байгуулах боломжийг олгох "Сити дашбсэрд"-ын техникийн даалгаврыг болосруулж салбар тус бүрээр ангилан дараах 11 төрлийн мэдээллийг агуулсан дашбоардыг хөгжүүлж байгаа бөгөөд нийслэлийн мэдээ, мэдээллийн	70%

						<p>www.ulaanbaatar.mn цахим хуудастай холбосон. Үүнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Хэсгийн ахлагч 2. Боловсрол 3. Өргөдөл, гомдол 4. Аюулгүй байдал – 3 дашбоард 5. Хөрөнгө оруулалт 6. Санхүү төсөв 7. Онлайн бизнес төв 8. Зам, тээвэр 9. Орон зай <p>Дээрх дашбоардад хариуцсан чиг үүргийн 11 байгууллага 14 хоног тутам мэдээ, мэдээллээ шинэчилж оруулах бөгөөд цаашид сити дашбоардаар дамжуулан нийслэл хотын замын түгжрэлийн мэдээлэл болон замын хөдөлгөөнтэй холбоотой мэдээллүүдийг нэг цонхноос харах боломжийг бий болгохоос гадна, хаана илүү түгжрэл үүсэж буй харах, түгжрэл үүсэж буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж оновчтой шийдвэр гаргах боломжтой болж байна.</p>	
11	Алслагдсан гэр хорооллын нэн шаардлагатай цэгийг интернетийн утасгүй сүлжээнд холбосон байна. НЗДҮАХ 4.1.3.2, НХТЖҮЧ 5.2.4	-	Сүлжээнд холбогдсон цэгийн тоо	6	10	<p>Нийслэлийн хэмжээнд хүн ам ихээр төвлөрдөг номын сан, амралт зугаалгын бүсийн судалгааг гаргаж нийт 20 цэг "Богд хааны ордон музей, Гандантагчилэн хийд, УБ төмөр замын буудал, Хүүхдийн урлан бүтээх төв, Жуховын хөшөө, музей, Монгол</p>	50%

						цэргийн музей, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Улсын төв номын сан, Улсын төв номын сангийн салбарууд, Налайх дүүргийн Соёлын ордон Багахангай дүүргийн соёлын ордонд шинээр утасгүй интернетийн үйлчилгээг хүргэхээр тоног төхөөрөмжийн тооцоо судалгаа техникийн даалгавар боловсруулагдсан бөгөөд 2023 оны нийслэлийн төсөвт санал хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй.	
12	Иргэн аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээний портал www.e-mongolia.mn системд холбосон байгууллагын тоог нэмэгдүүлнэ. НХТ-2023 3.1.2	-		29 байгуул лага, 320 үйлчилг ээ	35 байгуул лага, 320 үйлчилг ээ	Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn системийн дэд систем болох "E-Business" платформд Нийслэлийн "Онлайн бизнес төв"-өөр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нийслэлийн нутгийн захиргааны 10 байгууллагын зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй 134 үйлчилгээг нэгтгэн холбож үйлчилгээний тоог нэмэгдүүлсэн бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар 453466 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 12755 хүсэлтийг ирүүлснээс 8,571 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй байгаа ба уйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна.	100%
2	Зорилт 4.3 Иргэдийн аюулгүй, амар тайван байдлын зорилтот түвшинг бүрэн хангана. НХТЖҮЧ-7.3, НЗДҮАХ-6.3, НХТ- 6.1.						
13	Замын хөдөлгөөний удирдлага зохион байгуулалтын ухаалаг	-		30%	60%	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/207 дугаар захирамжаар	

	систем II шатны төслийг хэрэгжүүлнэ. НЗДҮАХ 6.3.11.3, НХТ 6.1.15		Төслийн хэрэгжилтийн хувь			нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд "Зам, тээврийн нэгдсэн систем"-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID tag/-г суурилуулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан бөгөөд нийслэлийн хэмжээнд 100 цэгээр дамжуулан 442477 тээврийн хэрэгсэлд цахим гэрчилгээг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн суурилуулахаар төлөвлөж байна.	70%
14	Нийслэлийн удирдлага, хяналтын цогц системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. НЗДҮАХ 4.3.1.1, НХТЖҮЧ 7.3.1	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	18%	50%	Нийслэлийн удирдлага, хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн дад систем болох нийслэлийн удирдлагуудыг бодитой хамжигдахуйц мэдээ мэдээллээр шуурхай хангах удирдлагын үйл ажиллагааг ухаалагаар удирдан зохион байгуулах боломжийг олгох "Сити дашбоард"-ын техникийн даалгаврыг боловсруулж салбар тус бүрээр ангилан дараах 11 төрлийн мэдээллийг агуулсан дашбоардыг хөгжүүлж нийслэлийн мэдээ, мэдээллийн www.ulaanbaatar.mn цахим хуудастай холбосон. Үүнд:	70%
						<ul style="list-style-type: none"> 10. Хэсгийн ахлагч 11. Болосрол 12. Өргөдөл, гомдол 13. Аюулгүй байдал – 3 дашбоард 14. Хөрөнгө оруулалт 	

						<p>15. Санхүү төсөв 16. Онлайн бизнес төв 17. Зам, тээвэр 18. Орон зай</p> <p>Дээрх дашбоардад хариуцсан чиг үүргийн 11 байгууллага 14 хоног тутам мэдээ, мэдээллээ шинэчилж оруулах бөгөөд цаашид сити дашбоардаар дамжуулан нийслэл хотын замын түгжрэлийн мэдээлэл болон замын хөдөлгөөнтэй холбоотой мэдээллүүдийг нэг цонхноос харах боломжийг бий болгохоос гадна, хаана илүү түгжрэл үүсэж буй харэх, түгжрэл үүсэж буй нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж оновчтой шийдвэр гаргах боломжтой болно.</p>	
15	Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглал /Giemmar, Compstab/-ыг Цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, камерыг "Камерын удирдлагын нэгдсэн төв"-тэй холбоно. НЗДҮАХ 4.3.1.2, НХТЖҮЧ 7.3.2	-	"Камерын удирдлагын нэгдсэн төв"-д холбосон камерын тоо	415	500	Улсын төсөв болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангийн хөрөнгө, дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх нийслэлийн ХУД, БЗД, СБД, СХД-ийн дүүргийн 218 цэгийн 606 камерын 24 техникийн даалгаврыг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд дээрх камеруудыг "Зам, тээврийн нэгдсэн систем"-ийн камерын хяналтын системд холбохоор ажиллаж байна.	50%
<p>Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго: Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй, хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. НЗДҮАХ-4.1</p>							

3	Зорилт 4.1.3 Нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгоно, НХТЖҮЧ-5.2, НЗДҮАХ-4.1, НХТ- 3.1					
16	Нийслэлийн Дотоод удирдлагын UB ERP системийн гар утасны аппликейшны нэмэлт хөгжүүлэлт хийнэ. НХТ 3.1.10	-	Системийн гар утасны аппликейшны нэмэлт хөгжүүлэлтийн хувь	50	90	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн UB ERP системийг нийслэлийн 1250 байгууллагын 28,400 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж албан бичгийг 100% цахимаар солилцож байна. "UB ERP" системийн гар утасны аппликейшны хөгжүүлэлтийн техникийн даалгаврыг боловсруулсан бөгөөд хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах "Эрх шилжүүлэх" НЗД-ын захирамжийн төсөлд санал авах шатанд явж байна. UB ERP систем дээр ННЗБ-уудын албан хаагчийн цаг бүртгэлийг зайнаас бүртгүүлэх мөн ННЗБ-уудын дарга нартай уулзалт хийх цаг захиалах болон албан хаагчдад өргөдөл гомдол илгээх дэд системүүдийн нэмэлт хөгжүүлэлтийг хийж байгаа бөгөөд 2023 оны 3-р улиралд хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.
17	Call center дуудлагын төвийг өргөжүүлж дахин загварчлан сайжруулалтыг хийнэ. НХТ 3.1.11	-	Системийн өргөтгөл, сайжруулалтын хувь	50	70	Нийслэлийн лавлагаа мэдээллийн төв буюу Call center дуудлагын төв 1800-1200 тусгай дугаарт Улаанбаатар хотын шуурхай удирдлага, зохицуулалтын төв, нийслэлийн Тээврийн үйлчилгээний газар, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Ус

						<p>сүвгийн удирдах газар, ОСНААУГ ОНӨААТҮГ-уудын тусгай дугааруудыг холбон 7/24 цагийн горимоор ажилладаг. "Call center" дуудлагын төвийг өргөжүүлэх тус төсөл, арга хэмжээний техникийн даалгаврыг боловсруулан Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж худалдан авах ажиллагааг зарласан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зогсоосонтой холбоотой хэрэгжүүлэх боломжгүй болсон.</p> <p>Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын чиг үүрэг өөрчлөгдсөнтэйгөөр холбогдуулан 70128012 дугаарыг Нийслэлийн лавлагаа мэдээллийн төв буюу Call center дуудлагын төвийн 1800-1200 дугаар руу нэгтгэж өөрчлөлт шинэчлэлт хийж 7/24 цагийн горимоор ажиллаж байна.</p>	50%
18	<p>Нийслэлийн алслагдсан 3 дүүргийг цахим мэдээллийн нэгдсэн сан, сүлжээнд холбож, дэд бүтэц сайжирсан байна. НХТЖҮЧ 5.2.1</p>	=	<p>Нэгдсэн сүлжээнд холбогдсон дүүргийн тоо.</p>	6	9	<p>Нийслэлийн жил бүрийн төсөвт нэгдсэн сүлжээнд холбогдоогүй алсын 3 дүүргийг холбох төсвийг нийслэлийн төсөвт санал хүргүүлдэг боловч төсөв батлагддаггүй бөгөөд нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй Налайх дүүргийн 7, Багануур дүүргийн 5, СБД-ийн 4, БХД-ийн 2 хороосдын сүлжээг хувийн хэвшлийн шилэн кабелиг түрээсээр ашиглаж төрийн үйлчилгээг</p>	100%

						цахимаар үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн.	
19	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байна. НХТЖҮЧ 5.2.3	-	Цахим аюулгүй байдлыг хангасан хувь	20	70	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хадгалах тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, сүлжээ, серверийн хэвийн найдвартай ажиллагааг хангах нийслэлийн Дата төвд зориулалт бүхий 12 рак, 88 физик сервер, 176 виртуал сервер, хадгалах төхөөрөмж, 130 систем, 278 цахим хуудасны мэдээлэл байрладаг бөгөөд тэдгээрийн хэвийн найдвартай 24/7 горимоор тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна.	100%

Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

20	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах	1,959.8 сая, төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Байгууллагын 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 31-ны байдлаар нийт 800,930,000 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн тухай хуульд зааснаар зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулж, санхүүгийн гүйцэтгэлийн тайланг сар, улиралаар нэгтгэн тухай бүрт нь тайлагнаж ажилласан.	100%
21	Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөржлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн 2023 оны төсөвт тусгагдсан нийслэлийн Замын сангийн хөрөнгөөр 1, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 1,	70%

	ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх					нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022-2023 он дамжин санхүүжих авто замын түгжрэлийг бууруулах жагсаалтад орсон 1 төсөл арга хэмжээ, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/506, А/1313, А/1369, 2023 оны А/207 дугаар захирамжуудаар эрх шилжсэн 10 төслүүдэд захиалагчийн хяналт тавьж хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.	
22	Байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулах.	-	Хөтөлбөрт хамрагдсан албан хаагчид, хувь	15	21	Байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2021-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөг батлуулсан бөгөөд Хөдөлмөрийн дотоод журмын 5.24-т заасны дагуу эмнэлгийн заалтаар яаралтай хагалгаанд орох болсон 1 албан хаагчид 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж, ажлын үр дүнгийн урамшууллыг хагас жилээр тооцож 23 албан хаагчид үндсэн цалингийн 80 хүртэл хуятай тэнцэх урамшууллыг тус тус олгосон. Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах төлөвлөгөө, хуваарь гарган хамруулж байгаа бөгөөд нийт хамруулах 16 хүнээс 8 албан хаагчийг хамруулаад байна.	70%
23	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих.	-	Тарьсан модны тоо	60	120	МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод"-ыг тарьж ургуулах үндэсний хөдөлгөөнийг байгууллагын	70%

						хэмжээнд дэмжин 2022 онд 66 суулгацыг суулгасан бөгөөд 2023 оны 05 дугаар сарын 13-ны өдөр "Ногоон хот-иргэний оролцоо" хаврын мод тарих аяны хүрээнд Айцын аманд 2022 онд тарьсан 66 ширхэг улиас моднуудын усалгаа арчилгааг хийж шинээр 15 мод шинээр нөхөн суулгаж суулгацынхаа тоог нэмэгдүүлсэн.	
24	Нийслэлийн Засаг даргыг шүүхэд итгэмжлэлээр төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу оролцох, үр дагаврыг нийслэлийн Засаг даргын өмнө бүрэн хариуцах.	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан хувь	100%	100%	Байгууллагын чиг үүргийн хүрээнд шүүхэд үүссэн маргаан байхгүй болно.	-
25	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах.	-	Хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан хувь	100%	100%	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагаврын талаар мэдлэг олгох, хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалтад байгууллагын бүх албан хаагчдыг хамруулж, иргэдийг энэ талаарх мэдээллээр хангах, хор уршгийг иргэдэд таниулах зорилгоор "Анзаар" аяны хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний танилцуулга, видео шторк, мэдээллийг байгууллагын цахим хуудсаар 2 удаа, фейсбүүк хуудсаар 1 удаа, нийслэлийн дотоод удирдлагын UBERP системээр 1 удаа тус тус мэдээллэж ажилласан.	70%

						Нийслэлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс нийслэлийн хууль, хяналтын байгууллагуудын удирдлага, хүний нөөцийн ажилтнуудад хүний эрх, хөдөлмөрлөх эрх, аюулгүй байдлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт болон Хүн бүр байгаль хамгаалагч аянд нэгдэж нэгдсэн зөвлөгөөнд тус тус 4 албан хаагчид хамрагдсан.	
26	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Байгууллагын албан хаагчдын хүйсийн харьцаа	50/47	50/50	Байгууллагын хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах, нөхцлийг бүрдүүлж ажиллаж байгаа бөгөөд албан хаагчдыг хүйсээр нь ангилвал эрэгтэй албан хаагч 13, эмэгтэй албан хаагч 11 ажиллаж байгаа нь хүйсийн харьцаа 40/50 хувь бөгөөд жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллаж байна.	100%
27	Цахим засаглалыг нэвтрүүлсэн гадны орнуудын туршлагыг судлах, олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг сайжруулах	-	Хамтын ажиллагаа тогтоосон байгууллагын тоо	2	5	Нийслэлд салбар бүрт цахим засаглалын төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх хүрээнд БНХАУ, БНСУ, Сингапур, Филиппин зэрэг улсуудаас туршлага судлан ажиллаж байгаа бөгөөд мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ижил чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчидтай 2 удаагийн цахим уулзалтыг зохион байгуулж, 3 албан хаагч БНХАУ, БНСУ-д сургалт, туршлага судлах арга хэмжээнд оролцож цахим засаглалын	70%

						төслүүдийн үр дүнг сайжруулах чиглэлд туршлага судалсан. ЖАЙКА-ийн Түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд Японы нэгдсэн нийгмийн зам, тээврийн төвөөс 2023 оны 06 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд Япон улсын Хоккайдо Обихиро хотод зохион байгуулсан зорчигчдын шугамын автобусны менежментийн туршлага судлах, хиймэл оюун ухаанаар автобусны үйл ажиллагааг сайжруулах төслийн сургалтад 3 албан хаагчид хамрагдсан.	
28	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримт бичгийг бүрдүүлэн архив бүрдүүлэх, баримт бичгийг нэр төрөл, зохион байгуулалт, он цаг, авч холбогдол зэрэг шинжүүдээр ангилан төрөлжүүлж, хэрэг бүрдүүлж буй байдалд хяналт тавих, арга зүйгээр хангах	-	Архивын нэгж бүрдүүлэлтийн хувь	100%	100%	Байгууллагын 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байгууллагын архивт баримт хүлээн авах төлөвлөгөө, хуваарийг 2023 оны 03 дугаар сарын 15 -нд газрын даргаар батлуулж 2023 оны 01 дүгээр улиралд багтаан авч нийт 69 ширхэг хадгаламжийн нэгжийг үүсгэж нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Байнга хадгалах 38 ХН • 70 жил хадгалах 5 ХН • Түр хадгалах 26 ХН 	100%
29	Хяналт-шинжилгээ, үнэлгээний жилийн ажлын төлөвлөгөөний дагуу бодлогын болон захирамжлалын баримт бичиг, хууль тогтоомж, өргөдөл гомдлын шийдвэрлэлт болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ,	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	98%	100%	Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хүрээнд Байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээний	70%

	<p>үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, хяналт тавих</p>				<p>жилийн ажлын төлөвлөгөөний дагуу хяналт, шинжилгээ үнэлгээний аргачлалаар хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 3 зорилтын 6 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 67%-тай байна. • Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2 зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилт 76.2% байна. • Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд 2 зорилтын 6 арга хэмжээний хэрэгжилт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 50% тай байна. • Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн өөрийн байгууллагад хамаарах засгийн газрын тогтоол 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 5, НЗД-ын захирамж 5, НЗД-ын зөвлөлийн хурлын тэмдэглэл 2 тус тус холбогдох заалтуудыг хяналтад бүртгэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд I, II, III, IV, V саруудын тайлан мэдээг хавсралт маягтын дагуу гарган
--	---	--	--	--	--

						албан бичгээр болон ERP системийн чатаар тус тус хүргүүлж ажилласан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 87,5%-тай газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар танилцуулж холбогдох мэдээ тайланг НЗДТГ-т тухай бүр нь хүргүүлж ажилласан.	
30	Авлигатай тэмцэх хууль, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн дагуу авах, тайлагнах, хяналт тавих		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Авлигын эсрэг хуулий үйлчлэлд хамаарах 15 албан тушаалтан 2022 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтыг "Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах зарим албан тушаалын жагсаалт"-ыг хүснэгтийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан тоотоор хүргүүлсэн бөгөөд хуулийн хугацаанд нь хөрөнгө орлогын шинэчилсэн мэдүүлгийг авч баталгаажуулж ажилласан. 2022 оны ХАСХОМ-ыг 15 мэдүүлэг гаргагчаас хугацаанд нь мэдүүлж, хянан, бүртгэн, баталгаажуулж, ХАСХОМ-1 тайлан, ХАСХОМ-2 тайланг тус тус НЗДТГ-т хүргүүлж ажилласан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу шинээр албан тушаалд томилогдох	100%

						Болон дэвшин томилогдох 3 албан хаагчийн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Аалигатай тэмцэх газарт хүргүүлж мөн Хувийн ашиг сонирхолын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ Аалигатай тэмцэх газрын цахим системд хугацаанд нь мэдүүлэх ажлыг зохион байгуулсан.	
Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хүрээнд хэрэгжүүлэх зорилт							
31	Нийслэлийн төр, захиргааны болон харьяа байгууллагуудаас үзүүлдэг үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн үйлчилгээний нэгдсэн платформыг хөгжүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх, НЦХМТГ-ийн дүрэм 4.1	-	Цахимжуулсан үйлчилгээ, хувь	30%	40%	Монгол Улсын Засгийн газраас Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн "E-Mongolia" системд төрийн байгууллагуудын салангид үйлчилгээнүүдийг тус системд нэгтгэх шийдвэр гарсантай холбоотой нийслэлийн нутгийн захиргааны 17 байгууллагын цахимаар үзүүлдэг 110 үйлчилгээг Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн e-mongolia.mn системд холбосон. Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээг цахимжуулсан НЗДТГ, УБЗАА, ЦЕГ, НАГ, НБОГ, НХБХГ, НГЗБА, НТГ, НАЖГ, НСУГ, НБГ, НОБГ, НЦУГ, ННТГ, НЦХМТГ, дүүргүүдийн Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс нийт 17 байгууллага байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn системийн дэд систем	100%

						<p>болгох "E-Business" платформд Нийслэлийн "Онлайн бизнес төв"-өөр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд зориулсан нийслэлийн нутгийн захиргааны 10 байгууллагын зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй 134 үйлчилгээ (13000 гаруй хүсэлтэд үндэслэн үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж байгууллага)-г нэгтгэн холбож үйлчилгээний тоог нэмэгдүүлсэн. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй автобус компаниуд одоогийн байдлаар зорчигчдынхоо тоог нарийн тогтоож, төлбөрөө бүрэн хурааж чадахгүй байгаа нь автобусны компаниуд болон нийслэлийн төсөв бүрдүүлтэд алдагдал үүсээж байгааг үндэслэн нарийвчилсан дүн шинжилгээ хийх, тохиромжтой арга хэмжээг авахаар Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка-ийн түншлэлийн хөтөлбөрийн ялов техникийн хамтын ажиллагааны хүрээнд судалгааны баг, НТҮГ-тай хамтран Хэрэглэгчдэд чиглэсэн автобусны удирдлагын Ноу-хау болон Дижитал (AI, IOT) технологийг хэрэгжүүлж 2 автобусанд туршилт хийж, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж хамтран ажилласан.</p>	
32	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийслэл түүний харьяа газруудад мэдээллийн технологийн	-	Үйл ажиллагааны	100%	100%		50%

	чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллах. НЦХМТГ-ийн дүрэм 4.2		хэрэгжилтийн хувь			Нийслэлийн нийтийн тээврийн газраас олгодог /Замын хөдөлгөөнд ачааны автомашин цагийн хязгаарлалттай зорчих, Хүүхэд тээвэрлэх автобусны, Ажилчдын автобусны/ түр зөвшөөрлүүдийг цахимаар олгох хөгжүүлэлт, нэвтрүүлэлтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн Тээврийн хэрэгслийн татвар төлөлтийг хариуцсан татварын байцаагчтай өдөр тутамд холбогдсон https://smartcar.mn системд хандсан иргэдийн татвар төлөлттэй холбоотой асуудлуудыг цаг алдалгүй харилцан шуурхай шийдвэрлэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үндэсний их баяр наадмын хурдан морины унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах хүрээнд Унаач хүүхэд, морины уяач, хурдан морины мэдээллийг урьдчилан бүртгэж баталгаажуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх "Бүртгэлийн цахим систем"-ийн техникийн даалгаврыг боловсруулж наадмын салбар комисст хүргүүлсэн бөгөөд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.	
33.	Газрын хариуцсан програм хангамж, системийн ашиглалтыг сайжруулж системийн хөгжүүлэлт, найдвартай ажиллагааг хангах. НЦХМТГ-ийн дүрэм 4.3	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%	Нийслэлийн хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн доорх системүүдийн сервер тоног төхөөрөмжүүдийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хангах, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт, техникийн туслалцаа дэмжлэг үзүүлж,	50%

					<p>мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна. Үүнд:</p> <p>1.Нийслэлийн Мэдээ мэдээллийн https://www.ulaanbaatar.mn/ цахим хуудас</p> <p>2.Нийслэлийн цахим үйлчилгээний http://eservice.ulaanbaatar.mn/ систем</p> <p>3.Нийслэлийн нутгийн захиргааны 1200 байгууллагын 30,000 гаруй албан хаагч өдөр тутамдаа ашиглаж үйл ажиллагаа явуулдаг дотоод удирдлагын https://erp.ulaanbaatar.mn/ системтэй холбоотой 5,600 гаруй дуудлага, 10,9000 гаруй чатанд хариуг өгч ажилласан.</p> <p>4.Тээврийн хэрэгслийн цахим үйлчилгээний https://smartcar.mn/ системээр дамжуулан тээврийн хэрэгслийн тэтгэр 4 тэрбум 360 сая төгрөг, зөрчлийн торгууль 9 тэрбум 420 сая төгрөг, зөрчлийн торгууль 4 тэрбум 292 сая төгрөг, хот хоорондын автозам ашигласны хураамжийг 3326 тээврийн хэрэгсэл 10,472,000 төгрөг төлсөн байна. Мөн системтэй холбоотой 2000 гаруй дуудлагад хариу өгч ажилласан. Мөн тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний Смарткар системд Нийтийн тээврийн газраас олгодог нийслэлийн замын хөдөлгөөнд ачааны автомашин цагийн</p>
--	--	--	--	--	---

					<p>хязгаарлалттай зорчих түр зөвшөөрөл, хүүхэд тээвэрлэх автобусны түр зөвшөөрөл, ажилчдын автобусны түр зөвшөөрлийн үйлчилгээг 2023 оны 01 сарын 02-ноос хэрэглээнд нэвтрүүлж, хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажилласан.</p> <p>5.Нийслэлийн харьяа байнгын ажиллагаатай хяналт тавьдаг 4 төвчөөд /Баруун туруун, Налайх Тэрэлж, Түргэний гол, Эмээлт/-ын төлбөр авах цэгт цахим төлбөрийн tovchoo.ulaanbaatar.mn системд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хот руу нэвтэрсэн нийт тээврийн хэрэгслийн тоо 2,849,383, орон нутгийн дугаартай тээврийн хэрэгсэл төлбөр авах цэгээр нэвтэрч нэхэмжлэх үүссэн төлбөрийн дүн 550,579,000 төгрөг байна.</p> <p>6.Архив албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн https://edoc.ulaanbaatar.mn</p> <p>7.Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн https://service.ulaanbaatar.mn/ систем өдөр тутам иргэдээс ирсэн 5-10 дуудлагыг цаг хугацаанд нь шуурхай шийдвэрлэж, 8500 гаруй иргэн аж ахуй нэгж байгууллага тус системээс үйлчилгээ аван үйл ажиллагаа явуулж байна. 2023 оны 06 дугаар сарын 05-ны байдлаар 453466 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 12755 хүсэлтийг ирүүлснээс 8,571 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон</p>
--	--	--	--	--	---

						<p>шийдвэрлэсэн төлөвтэй байгаа ба үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна.</p> <p>Нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон интернэтийн гэрээтэй 35 байгууллагын гэрээний хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>8.Нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбогдсон 15 байгууллагын 424 хэрэглэгчид хортой кодын эсрэг програм хангамжийг суулгаж хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <p>9.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ub.gov.mn домэйн дээр байрлах 278 цахим хуудасны нөөцлөлтийг тухай бүр хийн SSL-ийг сунган хэвийн ажиллагааг ханган ажилласан. Smartcar.mn, ulaanbaatar.mn, ublegal.mn, smartub.mn, manaikhoroo.mn веб сайтуудын домэйны гэрээний хугацааг сунгуулан хэвийн ажиллагааг ханган ажилласан.</p> <p>10.Гаднаас хандалттай Ulaanbaatar.mn домэйн бүхий вэб сайтууд, вэб серверүүд дээр шинээр SSL сертификатыг худалдан авч системүүд дээр тохиргоо хийсэн.</p> <p>11.smartcar.mn домэйний сертификатын хугацаа дууссан байсныг шинээр сунгаж SSL-ийн тохиргоо хийсэн.</p>	
34	Нутгийн захиргааны байгууллагуудад хариуцсан чиг үүргийн хүрээнд мэргэжил арга	-	Үйл ажиллагааны	100%	100%	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад чиг үүргийн хүрээнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч	70%

